

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2025 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
8.2	Цус ойртолтын хор уршиг, үр дагаврыг ойлгуулах, удам угсаагаа таньж мэдэх, удмын сангаа цэвэр ариун байлгах үгийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлах	Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо	Үгийн бичиг хөтлөдөг иргэдийн тоо нэмэгдсэн байна	Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын эмч мэргэжилтэн, ажилтан албан хаагчид тавдугаар сарын 16-нд "Үгийн бичиг хөтлөх" тухай сургалтад хамрагдсан. Сургалтыг Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Нарны алтан оньс" төрийн бус байгууллагын сургагч багш нар (С.Өргөнханд Б.Алтанцэцэг, н.Эрхэмбаяр) мөн Сэлэнгэ аймгийн "Ураг удам, өв соёлын холбоо"-ны гишүүн Д.Мягмаржав нар явуулж, үгийн бичиг хөтлөх тулгамдсан шаардлага, цус ойртолт түүний уршиг, үр дагавар, үгийн бичиглэл хийхэд холбогдох мэдээлэл, үлгэрчилсэн загвар, ураг төрлийн холбооны уламжлалт нэр нэршлийн талаар ярилцсанаас гадна үгийн бичиглэл хөтлөх үлгэрчилсэн загвар болон зураглал хийх аргачлалаар дадлага ажил хийж суралцсан.	100
8.3	Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, мэдээллийн дамжуулан хэрэглээр байгуулах зохион	Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо		Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 21 удаагийн танхимын сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 37364 иргэнийг хамруулжээ. Үүнд: Бага насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалт, сургууль, цэцэрлэгийн үдийн хоол, илчлэг тооцох аргачлал, яаралтай тусламж, эрүүл зохистой хооллолт, хоол тэжээл, хүнсний	100

				аюулгүй байдлын зөвлөмж, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сурьез, чихрийн шижин, гэмтлийн тусламж, чихрийн шижингийн өөрийн хяналт, амны хөндийн эрүүл мэнд, суудлын мэдрэлийн өвчлөлөөс сэргийлэх нь зэрэг сэдвүүд багтсан ба сургалт, арга хэмжээний үр дүнд дээд шатлалын эмнэлэг, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа сайжирч, нийт иргэдийн 35%-д хүрч ажиллаа.	
8.4	Хорт хавдар, өргөн тархалттай шинэ төрлийн болон сэргэж байгаа халдварт бүс өвчний тандалт судалгааг өргөжүүлж, халдварыг эрт илрүүлэх, тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо	Өвчлөлийн тоо буурсан байна	Зоонозын өвчин судлалын төвөөс "Заарт харх"-нд Бэтэг, Хулгана тахлын халдваржилтыг тогтоох тандалт судалгааг 11 Заарт харх, 1 булга олзворлон хийсэн. Ус намгийн шувуудын тандалт судалгааг Цагаан нуурт хийхэд Монгол цахлай-50, Хоньд, нангир-100, Гангар хун-140, Хөх дэглэй-5, Алаг шунгаах 1500 гаран нийт 1795 ш орчим шувууд тоологдсон. Нуурын орчим үхсэн шувууны сэг сэм ажиглагдаагүй. Хүдэр суманд 7 цэгт, Бугант тосгонд 4 цэгт, Алтанбулаг суманд 4 цэгт, Түшиг суманд 5 цэгт, Цагааннуур суманд 2 цэгт Зүүнбүрэн суманд 1 цэгээс нийт 421 хачиг цуглуулсан зүйлийн бүрдлийг тодорхойлоход 1. resultsatus, D. pitfalli зүйлийн хачгууд тодорхойлогдож шинжилгээгээр Риккетсиоз, Эрлихиоз зэрэг гарлаа. Боом өвчний голомт бүхий 4 сумдын 10 цэгт газраас 50 хөрсний дээж авч шинжилгээ хийхээр бэлдэж байна. Тайлангийн хугацаанд артерийн гипертензийн эрт илрүүлэгт нийт 40334 хүн	100

				буюу 55,5%, чихрийн шижин хэв шинж – 2 эрт илрүүлэгт нийт 38574 хүн буюу 53,1%, элэгний эрт илрүүлэгт нийт 34700 хүн буюу 47,8%, хөхний хорт хавдраас сэргийлэх эрт илрүүлэгт нийт 3913 хүн буюу 19,1%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх эрт илрүүлэгт нийт 1767 хүн буюу 24,5 %-тай - тай тус тус хамрагдсан байна. Умайн хүзүүний эрт илрүүлгээр Asc-Ut – 259, Asc-H – 59, Lsil – 76, Hsil – 8 тус тус шинэ илэрсэн өвчлөлийг лавлагаа шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулж онош батлуулах, батлагдсанг эмчилгээ хяналтад авч ажиллаж байна. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх хүний папиллома вирусийн эсрэг товлолын дархлаажуулалтад 2025 онд 11 настай эрэгтэй, эмэгтэй зорилтод насны 2348 хүүхэд хамруулахаас 1929 хүүхэд хамруулсан. Аймгийн Засаг даргын 118 тоот захирамжийн дагуу “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцин болон товлолын дархлаажуулалтын талаарх сургалтыг 2000 гаруй хүнд хийсний үр дүнд 2024 оны зорилтот насны хүүхдийн хамралт 34%-иас 73%, 2025 оны хамрагдалт 82,2%-тай болж нэмэгдсэн байна	
8.5	Эх нялхсын эндэгдлийг бууруулах чиглэлээр салбар дундын ажиллагааг сайжруулж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, төрөлхийн хөгжлийн гажгийг эрт оношлох арга хэмжээг	Зохин байгуулсан ажил, арга хэмжээний тоо	Эх нялхсын эндэгдлийн тоо буурсан байна	Улсын хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, 100.000 амьд төрөлтөд 37.5 ногдож байгаа ба манай аймаг 2025 онд эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдсэн. Эхийн эндэгдэл дахин гарахаас сэргийлж эхийн эндэгдэл хэлэлцэх, эмнэлэггүйн	90

	хэрэгжүүлэх		конференци, зөвлөлийн хурлыг зохион байгуулан, түүний гарсан шийдвэр зөвлөмжийн дагуу эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Нялхасын эндэгдэл улсын хэмжээнд 2025 оны 10 сарын байдлаар 621 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 13.7 байгаа ба манай аймгийн хувьд 9 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 10.9 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5 промиллоор өссөн үзүүлэлттэй байна. Эх, нялхасын чиглэлээр нийт 9 ажил үйлчилгээ зохион байгуулан ажилласан байна. Үүнд: 1. Анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллагуудад долоо хоног бүрийн 4 дэх өдрийн цаг үеийн мэдээллийн цагаар эхний эндэгдэл, ноцтой хүндрэл, 5 хүртлэх хүүхдийн эндэгдлийн чиглэлээр анхааруулах мэдээллийг цахимаар өгч ажилласан. Мөн Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт Судалгааны Албанаас зохион байгуулдаг "Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл"-ийн цахим хуралд холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулж байна. 2. Нялхасын эндэгдлүүдээс эмнэлэгт эндсэн 7 тохиолдлыг магадлан хэлэлцэх хурлыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж, эндэгдэлд судалгаа хийж, бууруулах чиглэлээр ажлыг зохион байгуулан ажилласан.
--	-------------	--	--

			3. Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт Судалгааны Албанаас зохион байгуулдаг "Нярай, 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, өнөөгийн байдал" сэдэвт цахим хуралд холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулж байна. 4. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар баталсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд төгсгөлийн үнэлгээ хийх, ололт амжилт, сургамжид дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарсан саад бэрхшээлүүдийг тодорхойлж, цаашид эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр арга хэмжээний санаг, зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх зорилготой Эрүүл мэндийн яам, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны ажлын хэсэг Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төв, Шаамар сумын эрүүл мэндийн төвд тус тус ажилласан. 5. Цагдаагийн байгууллагатай хамтран 2025 оны 1 дүгээр сард "Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж эрсдлийг бууруулъя" сарын аяныг өрнүүлж, нийтийн үйлчилгээний такси болон олон нийтийг хамарсан үйлчилгээний газруудад мөлхөө сурталчилгааг өрнүүлж, сэргийлж болох осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэхийг уриалж богино хэмжээний бичлэг, жолооч, эцэг эх асран хамгаалагчдын сургалт гэх
--	--	--	--

			мэт нөлөөллийн ажлыг хийсэн. 6. Аймгийн Засаг даргын 2024 оны А/487 “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай” захирамжийн дагуу салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахаар 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга, тосгоны төлөвлөгөөг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 7. Жирэмсний хяналтад хамрагдаж байгаа нийт 1094 эхчүүдэд жирэмсний 18-22 долоо хоногт ургийн анатомийн бүтцийн хэт авиан шинжилгээг ажиллаж байгаа ба төрөлхийн гажиг илрээгүй байна. 8. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/292 дугаар “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх, эх барихын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эхийн эндэгдэл, ноцтой хундрэлээс сэргийлэх зорилгоор “Монголын Эх Барих Эмэгтэйчүүдийн Эмч Нарын Холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Жирэмслэхээс өмнөх болон жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ” сэдэвт онол дэдлага хосолсон сургалтад эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, өрх, сум, тосгоны эмч нар нийт 62 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. 9. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын нийт 28 эх баригч бага эмч нарыг чадавхжуулах “ЭХ БАРИХЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ” сургалтыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх
--	--	--	--

			ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуультай хамтран зохион байгуулсан.	
--	--	--	---	--

Тайлан бичсэн:

П.Сэлэнгэ(НЭМТөвийн дарга)

Тайлан нэгтгэсэн:

С.Азжаргал(ЭТҮХДаргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Хянасан:

Ж.Од(ЭМГ азрын дарга)

